

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ БАТЛАХ ТУХАЙ

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 6.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл, ашиглалтын аюулгүй байдлын техникийн зохицуулалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Техникийн зохицуулалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/, Гаалийн ерөнхий газар /Б.Асралт/, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны ... дугаар сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Л.ХАЛТАР

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, АШИГЛАЛТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ

1. Зорилго

1.1. Энэхүү техникийн зохицуулалтын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн тээврийн хэрэгсэл нь хаана үйлдвэрлэгдсэнээс үл хамааран хөдөлгөөний болон техникийн аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангах болон тээврийн хэрэгслээс үүдэлтэй хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

2. Хамрах хүрээ

2.1. Энэхүү техникийн зохицуулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой бүх төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд, Монгол Улсын иргэн, Монгол Улсад суугаа гадаадын иргэд, жуулчид дагаж мөрдөнө.

2.2. Энэхүү техникийн зохицуулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний автозамаар зорчих L, M, N ба O ангиллын дугуйт тээврийн хэрэгсэл (цаашид тээврийн хэрэгсэл гэх), түүнчлэн тээврийн хэрэгслийн аюулгүй байдалд нөлөөлөх явах эд ангийн бүрэлдэхүүн хэсэгт хамаарна. Монгол Улсын тээврийн хэрэгслийн ангиллыг Хавсралт 1-д тусгав.

2.3. Энэхүү техникийн зохицуулалт нь дараахь тээврийн хэрэгсэлд хамаарахгүй:

2.3.1. Тээврийн хэрэгслийн дээд хурд 25 км/цагаас ихгүй байхаар зохион бүтээгдсэн;

2.3.2. Зөвхөн спортын тэмцээнд оролцох зориулалттай;

2.3.3. 30 ба түүнээс дээш жилийн ашиглалттай, L болон M1 ангилалын тээврийн хэрэгсэл, 50 ба түүнээс дээш жилийн ашиглалттай хүн болон ачаа тээвэрлэх зориулалтгүй, эх загвар хөдөлгүүр, бүхээг ба аралтай, эх загвар байдалаа хадгалсан эсвэл эх загвар байдалд хүртэл сэргээн засварласан тээврийн хэрэгсэл;

2.3.4. Монгол улсын нутаг дэвсгэрт 6 сараас илүүгүй хугацаагаар, гаалийн хяналт дор оруулж ирсэн тээврийн хэрэгсэл;

2.3.5. Дипломат болон консулын төлөөлөгчийн газрууд, олон улсын (Засгийн газар хоорондын) байгууллагууд, олон улсын хууль тогтоомж, гэрээний дагуу давуу эрх, дархан эрх эдэлдэг олон улсын (улс хоорондын) байгууллагууд, тэдгээрийн ажилтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдэд харьяалагддаг;

2.3.6. Бартаат замын хүнд даацын тээврийн хэрэгсэл;

2.3.7. Монгол улсын батлан хамгаалахын захиалгаар нийлүүлсэн тээврийн хэрэгсэл.

3. Норматив ишлэл

Энэ техникийн зохицуулалтад эш татаж хэрэглэсэн дараахь стандарт, баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийг хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.

- MNS ISO 1176 Автотээврийн хэрэгсэл. Масс. Тайлбар толь ба код;
- MNS ISO 612 Автотээврийн хэрэгсэл. Автомашин, чиргүүлийн хэмжээ. Нэр томьёо, тодорхойлолт;
- MNS ISO 3780 Автотээврийн хэрэгслийн - Дэлхийн үйлдвэрлэгчийг таних тэмдэг (WMI)-ийн код;
- MNS ISO 3779 Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) -Агуулга ба бүтэц;
- MNS 6512 Монгол Улсад үйлдвэрлэсэн авто тээврийн хэрэгсэлд MNS ISO 3779:2010 (VIN) стандартыг хэрэглэх заавар;
- MNS ISO 3833 Автотээврийн хэрэгсэл.төрөл, нэр томьёо, тодорхойлолт;

- MNS ISO 4030 Автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN) -байрлал ба бэхэлгээ;
- MNS 4410-1 Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг. Техникийн шаардлага;
- MNS 4410-2 Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага;
- MNS 4598 Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага;
- MNS 4599 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд;
- MNS 5011 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага;
- MNS 5044 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төв. Ангилал. Ерөнхий шаардлага;
- MNS 5013 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга;
- MNS 5014 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга;
- MNS 5025 Авто үйлчилгээ. Ангилал. Ерөнхий шаардлага;
- MNS 4979 Тээврийн хэрэгсэлд ашиглах тусгай дуут болон гэрлэн дохио. Ерөнхий шаардлага;
- MNS 6594 Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрлэл. Ерөнхий шаардлага;
- MNS 6224:2010 Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл угсрах үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага.

4. Нэр томьёо ба тодорхойлолт

Энэ техникийн зохицуулалтад хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

4.1. “Тээврийн хэрэгсэл” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасныг;

4.2. “Тээврийн хэрэгслийн аюулгүй байдал” гэж техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагыг бүрэн хангасан, хүрээлэн байгаа орчин, хүний эрүүл мэнд, амь насанд учруулж болох эрсдлийг бууруулахад чиглэгдсэн техникийн нөхцөлөөр тодорхойлогдох тээврийн хэрэгслийн хийцийн бүрэлдэхүүн хэсэг, нэмэлт тоног төхөөрөмжийн үзүүлэлт;

4.3. “Агаар бохирдуулах бодис” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасныг;

4.4. “Аюултай бохирдуулах бодис” гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасныг;

4.5. “Автомашин үйлдвэрлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт автомашин, иж бүрдэл, эд ангийг угсрах, зохион бүтээж, угсарч үйлдвэрлэх, эсвэл тус улсын газар нутгаас гадуур байнгын үйлдвэрлэл явуулах хаяг, байршил бүхий тээврийн хэрэгсэлд олгогдох зөвшөөрөлтэй холбоотой бүх талын хариуцлагыг хүлээх, үйлдвэрлэлээс гаргаж байгаа бүтээгдэхүүндээ баталгаа өгөх үүрэг бүхий хуулийн этгээд, хувь хүнийг;

4.6. “Автомашин дистрибьютер” буюу “үйлдвэрлэгчийн бүрэн эрхт төлөөлөгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, байнгын хаягтай, Монгол Улсын хууль болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу худалдааны бүрэн эрхт төлөөлөгчтэй гэрээ хийсэн, Монгол Улсын автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гадаадын үйлдвэрлэгчийн бүрэн эрхт төлөөлөгч гэдгээ баталгаажуулсан, үйлдвэрлэгчийн тэмдэг, лого ашиглах эрхтэй хуулийн этгээдийг;

4.7. “Автомашин диллер” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй, байнгын хаягтай, Монгол Улсын хууль болон тухайн улсын хууль тогтоомжийн дагуу дистрибьютер (үйлдвэрлэгчийн бүрэн эрхт төлөөлөгч)-тэй гэрээ хийсэн, Монгол Улсын автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв

байгууллагад худалдааны төлөөлөгч гэдгээ баталгаажуулсан, үйлдвэрлэгчийн тэмдэг, лого ашиглах эрхтэй, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд, хувь хүнийг;

4.8. “Тээврийн хэрэгслийг гүйлгээнд/зах зээлд оруулах” гэж тээврийн хэрэгсэл эсвэл тээврийн хэрэгслийн эд анги, хийцийн бүрэлдэхүүн хэсгийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, борлуулах үйл ажиллагаа;

4.9. “Тээврийн хэрэгслийг өөрчлөх” гэж авто зам хэрэглэгчийн аюулгүй байдалд нөлөөлөх үзүүлэлт бөгөөд тухайн тээврийн хэрэгслийг зах зээлд гарсанаас хойш түүний арал, үндсэн зангилаа, агрегатыг солих, суурилуулах, нэмэлт тоног төхөөрөмжөөр тоноглох үйл ажиллагаа;

4.10. “Тээврийн хэрэгслийн ашиглалт” гэж Автотээврийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15-д заасныг;

4.11. “Ашиглалтын хугацаа” гэж тээврийн хэрэгслийг бүртгэснээс (тээврийн хэрэгслийн зарим эд анги тухайлбал дугуйны хувьд үйлдвэрлэснээс хойш) хойш дахин боловсруулах, эсвэл устгах хүртэлх мөчлөг/хугацаа;

4.12. “Тээврийн хэрэгслийн ангилал” гэж нэг төрлийн загвар бүхий тээврийн хэрэгслийг хэлнэ.

4.13. “Тээврийн хэрэгслийн төрөл” гэж тухайн тээврийн хэрэгслийн ангилалд багтах үндсэн загварын тээврийн хэрэгслээс гадна тухайн загварын өөр хувилбар бүхий тээврийн хэрэгслийг хамаарна.

4.14. “Техникийн тодорхойлолт” гэж тээврийн хэрэгслийн бүтэц, хийцийг тодорхойлох үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн үзүүлэлт бүхий бичиг баримтыг хэлнэ.

4.1.15. “Бартаат замын хүнд даацын тээврийн хэрэгсэл” – Овор ихтэй, хүнд ачааг нийтийн эзэмшлийн авто замаас гадуур тээвэрлэх зориулалттай, тээврийн хэрэгслийн үзүүлэлтүүдийн аль нэг нь нийтийн эзэмшлийн автозамд ашиглах зөвшөөрөгдсөн хязгаараас хэтэрсэн бөгөөд дор хаяж нэг тэнхлэгт хамаарах жин нь 10 тонноос их, дотоод шаталтат хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл;

4.1.17. “Хилийн боомт дээрх техникийн хяналтын үзлэг” Тээврийн хэрэгслийн техникийн хяналт үзлэг хийх журам, түүний давтамж ба харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай 1997 оны НҮБ-ын Гэрээ, ЕЭЗК-ийн 1 ба 2-р Дүрэм, ЕХ-ны УДИРДАМЖ 2014/45/EU стандартын дагуу тээврийн хэрэгсэл үйлдвэрлэл, эд ангиудын тогтвортой байдлын шинж чанарыг баталгаажуулах зорилго бүхий тухайн улсын нутаг дэвсгэрт хийгдэх туршилт.

4.1.18. “Техникийн үйлчилгэний байгууллага”- Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн зохицуулалтыг хэрэглэх болон НҮБ-ын эдгээр зохицуулалтад үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай 1958 оны хэлэлцээрийн хүрээнд тээврийн хэрэгслийн хийцийн загварыг баталгаажуулах туршилт явуулах эрх бүхий байгууллага.

5. Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл, эд ангийг импортлоход тавих техникийн шаардлага

5.5.1. “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598 Үндэсний стандартад нийцсэн тээврийн хэрэгсэл, эд ангийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх;

5.5.2. Тухайн тээврийн хэрэгслийн техникийн тодорхойлолтод заасан экологийн стандартын түвшингийн шаардлагад нийцсэн байх;

5.5.3. Үйлдвэрлэгчийн загварын баталгааны гэрчилгээтэй, аюулгүйн тэмдэгтэй, үнэлгээний хуудастай тээврийн хэрэгсэл, эд ангийг Монгол Улсын зах зээлд нийлүүлэх ба худалдаалах;

5.5.4. Тээврийн хэрэгслийн ашиглалтын түүхтэй байх;

5.5.5. Автомашины албан ёсны дистрибьютер, диллерээр дамжуулан Монгол Улсын зах зээлд нийлүүлэх, худалдаалах;

5.5.6. Тээврийн хэрэгсэл нь зөвхөн зүүн талдаа жолооны хүрдтэй, үйлдвэрлэснээс хойш 7 ба түүнээс доош жилийн насжилттай байна. Энэхүү заалт нь тээврийн хэрэгслийг зөвхөн цуглуулга эсхүл үзэсгэлэнд зориулан ашиглах тохиолдолд хамаарахгүй.

5.5.7. Автотээврийн хэрэгслийн шингэрүүлсэн шатдаг /LPG/ хийн болон байгалийн шахсан /CNG/ хийн даралтад савны баталгаат хугацаа дуусаагүй байх;

5.5.8. Байгалийн давагдашгүй хүчин зүйл (үер, ус, цунами, гал г.м)-ийн нөлөөнд өртсөн, цацрагийн бохирдол илэрсэн, катализаторгүй тээврийн хэрэгсэл, эд ангийг Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглахыг хориглоно.

5.5.9. Үйлдвэрлэгдснээс хойш 3-аас дээш жил болсон, хээний элэгдэл нь 30 хувиас дээш болсон хуучин дугуй (бүх төрлийн тээврийн хэрэгслийн)-г Монгол Улсад ашиглахыг хориглоно.

5.5.10. Баримт бичгийн аливаа зөрчилгүй байх.

6. Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглах тээврийн хэрэгсэл, эд ангийн аюулгүй байдалд тавих техникийн шаардлага

6.1. Үйлдвэрлэгчийн загварын баталгааны гэрчилгээтэй, аюулгүйн тэмдэгтэй, үнэлгээний хуудастай тээврийн хэрэгсэл, эд ангийг Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглана;

6.2. Энэхүү техникийн зохицуулалтын 5 дугаар бүлэгт тусгагдсан техникийн шаардлагуудыг хангасан тээврийн хэрэгсэлд MNS 4410, MNS 4410-2 стандартын дагуу тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаар олгох замаар бүртгэлжүүлнэ.

6.3. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, тээврийн хэрэгслийн үйлдвэрийн хийцийг өөрчлөн тоногдсон, үйлдвэрлэсэн он болон арлын дугаарыг засварласан бол улсын бүртгэлийн гэрчилгээг олгохгүй.

6.4. Тээврийн хэрэгслийн бүх жин ба оврын зөвшөөрөгдөх дээд хэмжээ **Хавсралт 2-д** заасан шаардлагад нийцсэн байна.

6.5. M1 ба N1 ангиллын тээврийн хэрэгсэлд тулгуур гадаргуугийн хэвтээ хавтгай дээрх тээврийн хэрэгслийн проекцийн гаднах контурт харгалзах бамперийн шугамаас харьцангуй урагш илүү гарсан, ган эсвэл түүнтэй ижил төстэй бат бөх шинж чанар бүхий бусад материалаар хийгдсэн эд ангийг суурилуулахыг хориглоно. Энэхүү шаардлага нь тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчээс суурилуулсан болон зөвхөн улсын бүртгэлийн дугаарын пайз ба түүнийг бэхлэх хэрэгсэл, мөн гэрлийг хамгаалах зориулалттай 0.5 кг-аас ихгүй жинтэй метал сараалж бүхий зөвшөөрөгдсөн хийцэд хамаарахгүй.

6.6. Тээврийн хэрэгсэлд ашигладаг агааржуулагч болон хөргөлтийн тоног төхөөрөмжид Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 277 дугаар тогтоолоор батлагдсан озоны давхаргыг задалдаг бодисын жагсаалтад орсон материалыг ашиглахыг хориглоно.

6.7. Арилжааны зориулалтаар зорчигч ба ачаа тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл, аюултай ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь байршил тогтоох хиймэл дагуулын төхөөрөмж эсхүл түүнтэй ижил төстэй төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

6.8. Зорчигч тээвэрлэх зориулалттай M2, M3 ангиллын болон ачаа тээвэрлэх зориулалттай N2 ба N3 ангиллын тээврийн хэрэгсэл нь жолоочийн ажил, амралтын горимыг хянах, баталгаажуулах хяналтын төхөөрөмж (тахограф)-өөр тоноглогдсон байна.

6.9. Тээврийн хэрэгслийн засвар, техникийн үйлчилгээг үйлдвэрлэгчээс заасан хугацаа, технологи аргачлал, зааврын дагуу түүний аюулгүй байдлын түвшинг тухайн тээврийн хэрэгсэл ашиглаж эхлэх үеийн түвшингээс бууруулахгүйгээр тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэнэ.

6.10. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд ангид тавигдах шаардлагын жагсаалтыг энэхүү техникийн зохицуулалтын **Хавсралт 3-т** тогтоосон.

6.11. Тээврийн хэрэгслийн өмчлөгч нь энэхүү техникийн зохицуулалтаар зөвшөөрөөгүй сэлбэг, эд ангийг тээврийн хэрэгсэлд ашиглахыг хориглоно.

6.12. Монгол Улсад ашиглагдах тээврийн хэрэгслийн арал, үндсэн зангилаа, агрегатуудыг хийцийн хувьд үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүйгээр аливаа өөрчлөлт хийх ба нэмэлт тоног төхөөрөмжөөр тоноглохыг хориглоно.

6.13. Тээврийн хэрэгсэл өмчлөгч нь тээврийн хэрэгсэлд хийгдсэн засвар үйлчилгээ, сольсон болон засварласан сэлбэг, эд ангийн талаарх мэдээллийг авто үйлчилгээний мэдээллийн санд тухай бүр бүртгэх, бүртгүүлэх (үйлчилгээ авсан авто үйлчилгээний байгууллагаар) үүргийг хүлээнэ.

6.13. Монгол Улсын тээврийн хэрэгслийн засвар, техникийн үйлчилгээний мэдээллийн сан нь MNS ISO 18541-1, MNS ISO 18541-2, MNS ISO 18541-3, MNS ISO 18541-4, MNS ISO 18541-5, MNS ISO 18541-6 стандартын шаардлагыг хангасан байна.

7. Тээврийн хэрэгсэл, эд ангийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага

7.1. Автомашин үйлдвэрлэгч нь үер усны аюул, ус, намаг, цэвдэг, сул шороотой хөрс, хог хаях цэгээс тусгаарлагдсан, суурьшмал бүсийн гадна талд, үйлдвэрлэлийн бүсэд үйл ажиллагаагаа явуулна.

7.2. Үйлдвэрлэгч нь технологийн горим, эд анги, эцсийн бүтээгдэхүүнд сорилт туршилт, чанарын шинжилгээ хийх лаборторитой байх бөгөөд “MNS ISO IEC 17025 Сорилт ба шалгалт тохируулгын лаборторид тавих шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.

7.3. Автомашин үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн (угсарсан) бүтээгдэхүүн нь зохих техникийн норм, дүрэм, стандарт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан байх бөгөөд холбогдох байгууллагуудын туршилт, дүгнэлтээр баталгаажсаны үндсэн дээр худалдаанд нийлүүлэгдэнэ.

7.4. Холбогдох хууль тогтоомжийн дагуу, худалдаа эрхлэх зөвшөөрөл бүхий автомашины дистрибьютер, диллерээр дамжуулан бүтээгдэхүүнийг худалдан, зах зээлд нийлүүлнэ.

7.5. Автомашин үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь загварын баталгаажуулалтын гэрчилгээтэй, баталгааны тэмдэгтэй байна.

7.6. Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл, эд анги үйлдвэрлэх, худалдаалах зорилгоор улсын хилээр гаргах болон гаднаас нэвтрүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу хяналт, шалгалт хийлгэнэ.

7.7. Автомашин үйлдвэрлэгч нь эвдрэл, гэмтэл, саатал гарсан аливаа бүтээгдэхүүнийг зах зээлээс эргүүлэн татах ба энэ талаар дистрибьютер болон диллерүүдтэй албан ёсны гэрээ байгуулж ажиллана.

7.8. Зах зээлээс эргүүлэн татсан бүтээгдэхүүнийг дахин боловсруулалт хийх буюу эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн цэгт холбогдох хууль тогтоомжийн дагуу устгалд оруулна.

7.9. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэл нь Монгол Улсын стандарт (MNS), Олон Улсын стандарт (ISO), Нэгдсэн Үндэстний байгууллагын Европын Эдийн Засгийн Дотоодын тээврийн хорооны техникийн зохицуулалт (UNECE WP.29)-д нийцсэн байна.

7.10. Үйлдвэрлэгч нь эрх бүхий байгууллага нийлүүлэгч, үйлдвэрлэгчээс гаргасан чанарын баталгаатай, гарал үүслийн гэрчилгээтэй эд анги, материал, нэмэлт тоног төхөөрөмжөөр MNS 4598, MNS 4470, MNS 4601, MNS 6225, MNS 6310 үндэсний стандартад нийцсэн автотээврийн хэрэгсэл үйлдвэрлэж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу үйлдвэрлэлээс ашиглалтад шилжүүлнэ.

7.11. Чиргүүлийн хэрэгсэл, суудлын автомашины чиргүүлийг MNS 5394 үндэсний стандартын техникийн шаардлагын дагуу, MNS ISO 612 үндэсний стандартад заасан хэмжээ, нэр томъёо, тодорхойлолтод нийцүүлэн үйлдвэрлэнэ.

7.12. Үйлдвэрлэгч нь тээврийн хэрэгсэл үйлдвэрлэхдээ MNS ISO 3779, MNS ISO 3780, MNS ISO 4030, MNS 6512 үндэсний стандартуудад нийцүүлэн автотээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар (VIN)-ыг бүрдүүлнэ.

7.13. MNS ISO 3779, MNS ISO 3780, MNS ISO 4030, MNS 6512 үндэсний стандартуудад нийцүүлэн 500-аас дээш цуврал үйлдвэрлэх тохиолдолд Олон улсын авто инженерүүдийн холбоонд бүртгүүлэх ба 500-аас доош цуврал үйлдвэрлэхээр бол эрх бүхий байгууллагаас Олон улсын авто инженерүүдийн холбоотой зөвшилцсөний үндсэн дээр бүртгүүлнэ.

7.14. Үйлдвэрлэгч нь зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхдээ ялгах таних тэмдэг, тэмдэглэгээ, бүтээгдэхүүн тараалтын бүртгэл хөтөлж, архивлан хадгална.

7.15. Үйлдвэрлэлд шаардагдах тээврийн хэрэгслийн эд анги, нэмэлт төхөөрөмж нь үндэсний стандарт (MNS)-д заасан шаардлагад нийцсэн байх бөгөөд үйлдвэрлэгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнтэй холбоотой техникийн бичиг баримтыг олон улсад мөрдөгдөж буй стандарттай уялдуулан үндэсний стандартыг шинээр боловсруулан батлуулна.

7.16. Автотээврийн хэрэгсэл түүний эд ангийг зохион бүтээх, угсрах ажлын технологийн болон программын зураг төсөл, тооцоолол бүхий техникийн баримт бичгийг боловсруулан батлуулж, цахим болон цаасан хэлбэрээр хадгална.

7.17. Хувийн хэрэгцээнээс бусад тээврийн хэрэгслийг хуучин эд ангиар үйлдвэрлэх, угсрахыг хориглоно.

8. Тээврийн хэрэгсэл, эд ангийг ашиглалтаас хасах болон дахин боловсруулах үйл ажиллагаанд тавигдах шаардлага

8.1. Тээврийн хэрэгслийн өмчлөгч нь ашиглалтаас хасагдах тээврийн хэрэгслийг дахин боловруулах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч, гэрчилгээ авсан байна. Гэрчилгээнд өмчлөгчийн нэр, тээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар, арлын дугаар, тээврийн хэрэгслийн

төрөл болон бусад мэдээлэл багтсан байна. Гэрчилгээний загварыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батална.

8.2. Тээврийн хэрэгслийг дахин боловсруулах байгууллагаас тээврийн хэрэгслийн үнэлгээг тээврийн хэрэгслийн өмчлөгчтэй тохиролцож тогтооно.

8.3. Тээврийн хэрэгслийг дахин боловсруулах эрх бүхий байгууллага нь авто үйлчилгээний байгууллага байх бөгөөд Автотээврийн тухай хуульд тавигдсан шаардлагыг хангасан, эрх үүргийг хүлээнэ.

8.4. Тээврийн хэрэгслийг дахин боловсруулах байгууллага нь “Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрлэл. Ерөнхий шаардлага MNS 6594:2016” Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байна.

8.5. Ашиглалтаас хасагдах тээврийн хэрэгслийг дахин боловруулах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгч, гэрчилгээ авсны дараагаар тээврийн хэрэгслийн өмчлөгч нь ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг нэг сарын дотор улсын бүртгэлээс хасуулна. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулахад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын албан бичиг, хувь хүний өргөдөл
- аймаг, нийслэлийн татварын албанаас татварын өргүй болохыг баталсан гэрчилгээ
- ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг хүлээн авсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ.

9. Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, засвар, үйлчилгээ, татвар, даатгалын нэгдсэн системд тавих ерөнхий шаардлага

9.1. Тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн засвар, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын нэгдсэн системтэй байна. Энэхүү систем нь Монгол Улсын хэмжээнд нэгдмэл байна.

9.2. Тээврийн хэрэгслийн бүртгэл, техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн засвар, татвар, даатгалын нэгдсэн систем дэх мэдээлэл нь нэг цонхны нэгдсэн нэг платформд суурилагдсан байна.

9.3. Хэрэглэгчдэд ээлтэй интерфэйс платформыг ашиглан тээврийн хэрэгсэлтэй холбоотой шаардлагатай мэдээллийг батлагдсан маягтын дагуу түгээх ба цуглуулна.

10. Тохирлын үнэлгээний үйл ажиллагаа

10.1. Тээврийн хэрэгсэлд хилийн боомт дээрх техникийн хяналтын үзлэг явуулах болон ашиглалтын үеийн техникийн хяналт явуулах байгууллага нь ISO/IEC 17020 стандартын дагуу итгэмжлэгдсэн техникийн үнэлгээний байгууллага байна.

10.2. Техникийн хяналтын үзлэгт орж тэнцсэн тээврийн хэрэгслийг дараах тохиолдолд дахин техникийн хяналт үзлэгт хамруулж “тээврийн хэрэгслийн аюулгүй байдал”-ын шаардлага хангасан тохиолдолд замын хөдөлгөөнд оролцохыг зөвшөөрнө. Үүнд:

- зам тээврийн ослын улмаас тээврийн хэрэгслийн явах анги, ослоос хамгаалах дэр, жолооны ба тоормосны системд гэмтэл согог үүссэн;
- тээврийн хэрэгслийн техникийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах систем, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг өөрчилсөн;
- тээврийн хэрэгслийн өмчлөгч өөрчлөгдсөн;

10.3. Тээврийн хэрэгслийн төрлийг батлах зорилгоор тохирлын үнэлгээ хийх байгууллага нь ISO/IEC 17065 стандартын дагуу итгэмжлэгдсэн техникийн байгууллага байна.

10.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр угсарч, үйлдвэрлэх тээврийн хэрэгсэл, эд ангийг техникийн баримт бичигт нийцүүлэн цувралаар үйлдвэрлэхийн өмнөх “туршилтын загвар”-ыг үйлдвэрлэнэ. “Туршилтын загвар”-т урьдчилсан ба хүлээн авалт, баталгаажуулалтын гэсэн хоёр төрлийн сорилт, туршилт хийнэ.

10.5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын, экологийн, эргономикийн, ерөнхий аюулгүй байдлын шаардлага хангасан эсэхийг гэрчлэх сорилт туршилтыг хийж, “тохирлын гэрчилгээ”-д тусгана.

10.6. Тохирлын гэрчилгээ нь Монгол Улсад болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон бүс нутгийн гэрээ, хэлэлцээр, мөн худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн хэлэлцэн тохиролцогч орнуудад хүчин төгөлдөр үйлчилнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ

Хүснэгт 1.

Д/д	Монгол Улсын тээврийн хэрэгслийн ангилал
1	L ангилал- Хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл. Үүнд:
1.1	<p>Мопед, моторт дугуй, мокик. Үүнд:</p> <p>L1 ангилал- тооцоологдсон хамгийн дээд хурд нь 50 км/цаг-аас хэтрэхгүй бөгөөд дараахь онцлог шинж чанар бүхий хоёр дугуйтай тээврийн хэрэгсэл:</p> <ul style="list-style-type: none"> ▪ дотоод шаталтын хөдөлгүүрийн хувьд хөдөлгүүрийн ажлын багтаамж 50 см³ -ээс хэтрэхгүй, эсхүл ▪ цахилгаан хөдөлгүүрийн хувьд тасралтгүй ачааллын горим дахь боломжит хамгийн их хүч нь 4 кВт-аас хэтрэхгүй. <p>L2 ангилал- дугуйны байршлын хувьд дурын зохион байгуулалттай, тооцоологдсон хамгийн дээд хурд нь 50 км/ч-аас хэтрэхгүй, дараахь онцлог шинж чанар бүхий гурван дугуйтай тээврийн хэрэгсэл:</p> <ul style="list-style-type: none"> ▪ албадан ноцоолттой дотоод шаталтын хөдөлгүүрийн хувьд хөдөлгүүрийн ажлын багтамж нь 50 см³-ээс хэтрэхгүй, эсвэл ▪ өөр төрлийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хувьд хамгийн их үр ашигтай хүч нь 4 кВт-аас хэтрэхгүй, эсвэл ▪ цахилгаан хөдөлгүүрийн хувьд тасралтгүй ажиллах горимд тохиромжтой хамгийн их чадал нь 4 кВт-аас хэтрэхгүй
1.2	<p>Мотоцикл, скутер (мотороллер), гурван дугуйтай мотоцикл. Үүнд:</p> <p>L3 ангилал- 50 см³-ээс их цилиндрин багтаамж бүхий ДШХ-тэй, 50 км/цаг-аас дээш техникийн хурдтай, тээврийн хэрэгслийн дагуу дунд хавтгай (тэгш хэмийн дагуу хавтгай)-д тэгш бус хэмтэй байрласан гурван дугуйтай тээврийн хэрэгсэл</p> <p>L4 ангилал- Тээврийн хэрэгслийн төвийг дайрсан дагуу хавтгайтай харьцуулахад тэгш хэмтэй бус байрласан дугуйтай, хөдөлгүүрийн багтаамж(дотоод шаталтын хөдөлгүүрийн хувьд) нь 50 см³-ээс дээш ба (эсвэл) тооцоологдсон хамгийн дээд хурд (ямар ч хөдөлгүүрийн хувьд) нь 50 км/цаг-аас дээш гурван дугуйтай тээврийн хэрэгсэл</p> <p>L5 ангилал- 50 см³-ээс их цилиндрин багтаамж бүхий ДШХ-тэй, 50 км/цаг-аас дээш техникийн хурдтай, тээврийн хэрэгслийн дагуу дунд хавтгайд тэгш хэмтэй байрласан гурван дугуйтай тээврийн хэрэгсэл</p>
1.3	<p>Гурван дугуйтай мотоцикл. Үүнд:</p> <p>L6 ангилал- 50 см³– ээс ихгүй хөдөлгүүрийн цилиндрин багтаамж бүхий ДШХ-тэй эсвэл 4 кВт-аас ихгүй чадал бүхий цахилгаан хөдөлгүүртэй (цахилгаан тээврийн хэрэгслийн хувьд батерейн жинг оруулахгүй), 45 км/цаг-аас хэтрэхгүй техникийн хурдтай, ачаалаагүй үеийн жин 350 кг-аас ихгүй дөрвөн дугуйтай бага оврын тээврийн хэрэгсэл;</p> <ul style="list-style-type: none"> – албадн ноцоолттой дотоод шаталтат хөдөлгүүрийн хувьд , хөдөлгүүрийн ажлын багтаамж 50 см³-ээс ихгүй, эсвэл – өөр төрлийн дотоод шаталтын хөдөлгүүрийн хувьд, хөдөлгүүрийн хамгийн их чадал нь 4 кВт-аас хэтрэхгүй, эсвэл – цахилгаан хөдөлгүүрийн хувьд, тасралтгүй ачааллын горимд хөдөлгүүрийн тохиромжтой хамгийн их чадал нь 4 кВт-аас хэтрэхгүй. <p>L7 ангилал - 6 ангилалд ороогүй, цахилгаан тээврийн хэрэгслийн хувьд батерейн жинг оролцуулалгүйгээр тээврийн хэрэгслийн ачаалаагүй үеийн жин нь 400 кг-аас ихгүй</p>

	(ачаатай үед 550 кг) ба хамгийн их тогтмол чадал нь 15 кВт-аас хэтрэхгүй дөрвөн дугуйтай бага оврын тээврийн хэрэгсэл
2	M ангилал – дөрвөөс цөөнгүй дугуйтай, зорчигч тээвэрлэх зориулалтын механикжсан тээврийн хэрэгсэл
2.1	M1 ангилал - Жолоочийн суудлаас гадна 8-аас илүүгүй зорчигчийн суудалтай, зорчигч тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл
2.2	Автобус, троллейбус, зорчигч тээвэрлэх тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл ба тэдгээрийн явах анги. Үүнд: M2 ангилал - Жолоочийн суудлаас гадна 8-аас дээш суудалтай, хамгийн их жин нь 5 тн-оос хэтрэхгүй, зорчигч тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл M3 ангилал - Жолоочийн суудлаас гадна 8-аас дээш суудалтай, хамгийн их жин нь 5 тн-оос дээш, зорчигч тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгсэл Жолоочоос гадна 22 -оос илүүгүй багтаамжтай M2 ба M3 ангилалын тээврийн хэрэгслийг зогсоогоор болон суудал дээр зорчигч тээвэрлэх зориулалттай А анги, зөвхөн суудал дээр зорчигч тээвэрлэх зориулалттай В ангид хуваана. Жолоочоос гадна 22-оос илүү зорчигчийн багтаамжтай M2 ба M3 ангиллын тээврийн хэрэгслийг зорчигчдыг зогсоогоор тээвэрлэхэд зориулагдсан тусгай талбайтай бөгөөд зорчигчдийг хурдан сэлгэх боломж бүхий I анги, зорчигчдыг голдуу суудал дээр тээвэрлэхэд зориулагдсан бөгөөд дамжих хэсэгт ба (эсхүл) зорчигчийн зэрэгцээ хоёр суудлын талбайгаас хэтрэхгүй талбайд зорчигчдыг зогсоогоор тээвэрлэх боломж бүхий II анги, ба зорчигчдийг зөвхөн суудал дээр тээвэрлэхэд зориулагдсан III анги гэж хуваана.
3	N ангилал (дөрвөн дугуйтай, ачаа тээвэрлэх зориулалтын механикжсан тээврийн хэрэгсэл)
3.1.	N ангилал- Ачаа тээвэрлэхэд ашигладаг тээврийн хэрэгсэл – ачааны автомашин ба түүний явах анги. Үүнд: N1 ангилал - Хамгийн их жин нь 3.5 тн-оос ихгүй ачаа тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл N2 ангилал - Хамгийн их жин нь 3.5 тн-оос дээш, 12 тн-оос хэтрэхгүй ачаа тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл N3 ангилал- Техникийн хувьд зөвшөөрөгдөх дээд их нь 12 тонноос дээш, ачаа тээвэрлэхэд зориулагдсан тээврийн хэрэгсэл.
4	O ангилал (Чиргүүл /хагас чиргүүлийг оролцуулаад/)
4.1.	O1 ангилал – Техникийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин нь 0.75 тн-оос ихгүй чиргүүл. O2 ангилал – Техникийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин нь 0.75 тн-оос дээш 3.5 тн-оос ихгүй чиргүүл. O3 ангилал – Техникийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин нь 3.5 тн-оос дээш 10 тн-оос ихгүй чиргүүл. O4 ангилал – Техникийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин нь 10 тн-оос дээш чиргүүл.
ТАЙЛБАР: <ol style="list-style-type: none"> Жолоочийн суудлыг эс тооцвол, наймаас илүүгүй суудалтай зорчигч ба ачаа тээвэрлэхэд зориулагдсан тээврийн хэрэгсэл дараахь ангилалд хамаарна: <ul style="list-style-type: none"> Хэрэв хийцийн хувьд урьдчилан тооцоолсон зорчигчийн тоог нэг зорчигчийн жишиг жин(68 кг) -ээр үржүүлсэн үржвэр нь зорчигчтой хамт тээвэрлэсэн ачааны тооцоолсон жингээс хэтэрсэн бол M1; Хэрэв энэ нөхцөл биелэгдэхгүй бол, N. Хүндийн төвд ойрхон холбогддог хагас чиргүүл ба чиргүүлийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин гэдэгт чирэгчтэй холбогдсон хүндийн төвд ойрхон холбогддог хагас чиргүүл ба чиргүүлийн тэнхлэг эсхүл тэнхлэгүүдээр газарт дамжиж буй статик босоо ачааллыг тооцно. Чирэх хэрэгслийн тэнхлэг (-үүд) нь хүндийн төвд ойр байрласан хагас чиргүүл ба чиргүүлийн 	

хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин гэдэгт чирэгчтэй холбосон хагас чиргүүл ба чиргүүлийн чирэх хэрэгслийн тэнхлэг эсвэл тэнхлэгүүдээр газарт дамжиж буй статик босоо ачааллыг тооцно.

4. Энэхүү хавсралтын 1.1-р заалтын зорилгоор тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл (автокран, ажлын тавцан дээр өргүүр тоногдсон тээврийн хэрэгсэл, чирэгч машин г.м) дээр байрлуулсан тоног төхөөрөмж болон суурилуулалтыг ачаатай адилтган үзнэ

Хүснэгт 2.

Д/д	Монгол Улсын тээврийн хэрэгслийн ангилал
1	Г ангилал - Туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл
1.1.	Энэхүү хэсэгт тусгагдсан шаардлагыг хангаж буй М ба N ангиллын тээврийн хэрэгслүүдийг бартаат замын (туулах чадвар өндөртэй) тээврийн хэрэгсэл гэж үзнэ.
1.1.1.	Хамгийн их жин нь 2 тн-оос ихгүй N1 ангиллын тээврийн хэрэгсэл ба хэрэв дор дурдсан тоноглолтой бол бартаат замын (туулах чадвар өндөртэй) тээврийн хэрэгслээр тооцогддог M1 ангиллын тээврийн хэрэгсэл:
	Хамгийн багадаа урд нэг тэнхлэг ба хойд нэг тэнхлэг нь нэг зэрэг хөтлөх, үүнд нэг тэнхлэг нь хөтлөх тээврийн хэрэгсэл мөн багтана;
	Хамгийн багадаа нэг дифференциал түгжигч механизм, эсвэл үүнтэй ижил төстэй нэг механизмтай;
	Дан тээврийн хэрэгслийн хувьд хамгийн багадаа 30 хувийн налуу газар явах чадвартай;
	Дор дурдсан 6 шаардлагаас хамгийн багадаа 5 шаардлагыг хангасан байх: <ul style="list-style-type: none"> ▪ урд шүргэх өнцөг хамгийн багадаа 25⁰ байх; ▪ хойд шүргэх өнцөг хамгийн багадаа 20⁰ байх; ▪ тэгнэх өнцөг хамгийн багадаа 20⁰ байх; ▪ урд тэнхлэгийн тулах цэгийн өндөр хамгийн багадаа 180 мм; ▪ хойд тэнхлэгийн тулах цэгийн өндөр хамгийн багадаа 180 мм; ▪ Тэнхлэг хоорондын тулах цэгийн өндөр хамгийн багадаа 200 мм.
1.2.	Хамгийн их жин нь 2 тн-оос дээш N1 ангиллын тээврийн хэрэгсэл ба хэрэв бүх дугуй нь зэрэг хөтлөх байхаар үйлдвэрлэгдсэн /нэг тэнхлэг нь хөтлөх тээврийн хэрэгслийг оролцуулан/ бол, эсвэл дор дурдсан 3 шаардлагыг хангаж буй хамгийн их жин нь 12 тн-оос хэтрэхгүй, бартаат замын (туулах чадвар өндөртэй) тээврийн хэрэгсэлд тооцогдох N2, M2, M3 ангиллын тээврийн хэрэгсэл:
	Хамгийн багадаа нэг урд ба нэг хойд тэнхлэгтэй ба эдгээр нь зэрэг хөтлөхөөр үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл, үүнд нэг тэнхлэг нь хөтлөх тээврийн хэрэгслүүд мөн багтана.
	Хамгийн багадаа нэг дифференциал түгжигч механизм эсвэл үүнтэй ижил төстэй нэг механизмтай;
	Дан тээврийн хэрэгслийн хувьд хамгийн багадаа 25 хувийн налуу газар явах чадвартай;
1.3	Хамгийн их жин нь 12 тн-оос дээш M3 ангиллын тээврийн хэрэгсэл ба хэрэв бүх дугуй нь зэрэг хөтлөхөөр үйлдвэрлэгдсэн /нэг тэнхлэг нь хөтлөх тээврийн хэрэгслийг оролцуулан/ бол, эсвэл дор дурдсан шаардлагуудыг хангаж буй бартаат замын (туулах чадвар өндөртэй) тээврийн хэрэгсэлд тооцогдох N3 ангиллын тээврийн

	хэрэгсэлд тооцно:
	Дугуйнууд нь хөтлөх байх
	Хамгийн багадаа нэг дифференциал түгжигч механизм, эсвэл үүнтэй ижил төстэй нэг механизмтай
	Дан тээврийн хэрэгслийн хувьд хамгийн багадаа 25 хувийн налуу газар явах чадвартай;
	Дараах зургаан шаардлагаас наад зах нь дөрвийг нь хангасан байна. Үүнд:
	<ul style="list-style-type: none"> ▪ урд шүргэх өнцөг хамгийн багадаа 25° байх; ▪ хойд шүргэх өнцөг хамгийн багадаа 25° байх; ▪ тэгнэх өнцөг хамгийн багадаа 25° байх; ▪ урд тэнхлэгийн тулах цэгийн өндөр хамгийн багадаа 250 мм; ▪ тэнхлэг хоорондын тулах цэгийн өндөр хамгийн багадаа 300 мм; ▪ хойд тэнхлэгийн тулах цэгийн өндөр хамгийн багадаа 250 мм;
1.2.2.	G ангилалын тээврийн хэрэгслийн суурь (явах анги) дээр суурилуулсан тусгай ба тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл дээрх дэд хэсэг 1.2.1-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд түүнийг G ангилалд хамааруулна.
1.2.3.	<p>Туулах чадвар сайтай тээврийн хэрэгслийн ангилалыг тэмдэглэхдээ G үсгийг M эсвэл N үсэгтэй хослуулна (жишээ нь: N1G).</p> <p>Тайлбар:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тээврийн хэрэгслийн G ангилалд ангилах үзлэг явуулахдаа техникийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин нь 2 тонноос ихгүй N1 ангиллын тээврийн хэрэгсэл, болон M1 ангиллын тээврийн хэрэгслийг бүрэн байдалд байлгах ба өөрөөр хэлбэл, хөргөлтийн шингэн, тослох материал, түлшээр дүүргэж, багаж хэрэгсэл, нөөц дугуйгаар тоноглож мөн жолоочийн стандарт жинг 75 кг-тай тэнцүү хэмжээгээр тооцно. 2. Бусад тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгчийн тогтоосон техникийн хувьд зөвшөөрөгдөх хамгийн их жин хүртэл ачаалсан байна. 3. Тээврийн хэрэгслийн хувьд тогтоосон утга (25% эсвэл 30%)-ыг давж гарах чадварыг тооцооллын аргаар баталгаажуулна.

ХАВСРАЛТ 2

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ОВОР БА ЖИНГИЙН ХЯЗГААР

1. Тээврийн хэрэгслийн хэмжээст тавигдах шаардлага

1.1. Хамгийн их урт нь дараахь хэмжээнээс хэтрэхгүй байна. Үүнд:

- M1, N ба O(чиргүүлийн) ангилалын дан тээврийн хэрэгслийн -12 м;
- M2 ба M3 ангилалын хоёр тэнхлэгтэй дан тээврийн хэрэгслийн -13.5 м;
- хоёроос дээш тэнхлэгтэй M2 ба M3 ангиллын дан тээврийн хэрэгслийн- 15м;
- чирэгч ба чиргүүл(хагас чиргүүл)-ээс бүрдсэн авто угсрааны – 20 м;
- M2 ба M3 ангиллын угсраа автобусны – 18.75 м.

1.2. M3, N3, ба O ангилалын тээврийн хэрэгслийн жингийн параметрт тавигдах шаардлага

1.2.1. Тээврийн хэрэгслийн хамгийн их жин нь Хүснэгт 2-д заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.

Хүснэгт 2

Тээврийн хэрэгслийн ангилал, тэнхлэгийн нийт тоо	Зөвшөөрөгдсөн хамгийн их жин, т
Дан:	
М3, N3 ангилал:	
2	18
3 (М3 ангилалын угсраа автобусаас бусад)	25
3 (М3 ангилалын угсраа автобус)	28
4 (хоёрхөтлөгдөх тэнхлэгтэй)	32
Автоцуваа:	
3	28
4	36
5 ба түүнээс дээш	44

1.2.2. Тээврийн хэрэгслийн нэг тэнхлэг (бүлэг тэнхлэг) дээрх хамгийн их жин нь Хүснэгт 2-т заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байна.

Тэнхлэг хоорондын зай, м	Нэг тэнхлэг(бүлэг тэнхлэг)-т зөвшөөрөгдсөн хамгийн их жин, т
2-оос дээш	11.5 (10)
1.65-аас 2 хүртэл (2 орно)	10.5 (9)
1.35-аас 1.65 хүртэл (1.65 орно)	9 (8)
1-ээс 1.35 хүртэл (1.35 орно)	8 (7)
1 хүртэл	7 (6)

ТАЙЛБАР: Хаалтанд заасан утга нь зураг төсөл, барилга угсралт, сэргээн засварлалтыг тээврийн хэрэгслийн тэнхлэгийн 10 кН стандарт ачаалал дор гүйцэтгэсэн автозам дээр тусгай зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөн хийх зөвшөөрөгдөх дээд хэмжээ болно.

1.2.3. Ачаалагдсан нэг тэнхлэгтэй чиргүүл (буудаг чиргүүл)-ийн холбох гогцооноос тээврийн хэрэгслийн зүтгүүрийн төхөөрөмж дээрх босоо статик ачаалал нь 400Н -оос хэтрэхгүй байна.

Чиргүүлийн холбох гогцооноос босоо статик ачаалал 490Н-оос дээш байх тохиолдолд урд тулгуур хөл нь чиргүүлийг чирэгчтэй холбох (салгах) байрлалд холболтын гогцоог тохируулдаг өргөх-буулгах механизмаар тоноглогдсон байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх эд ангид тавигдах нэмэлт шаардлага

P/p No.	Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн хэсэг	Шаардлага эсвэл шаардлагыг агуулсан баримт бичгийн нэр
нэг.	Тоормос болон түүний эд анги	НҮБ-ын 13-10 эсвэл 13-11, 13Н-00 журмын дагуу
2.	Хурдны хайрцаг болон түүний эд анги,	
3.	Цохилт-зөөллөгч систем болон түүний эд анги хамаарна (амортизатор орно)	НҮБ-ын 67-01, 110-00, 115-00 дугаар журам.
4	Яндангийн хий цэвэршүүлэх систем, түүний дотор сольж болох каталитик хөрвүүлэгч (мочевин дээр суурилсан саармагжуулах системийг эс тооцвол)	НҮБ-ын 103-00 дугаар журам. Үүнээс гадна: НҮБ-ын журам No 83-05 эсвэл 83-06.